

**УЛААНБААТРААС ЗАМЫН-ҮҮД ОРЧИМ БАЙГАА
МОНГОЛ-ХЯТАДЫН ХИЛ ХҮРТЭЛ ТӨМӨР ЗАМЫН
ШУГАМЫГ БАЙГУУЛАХ БА АШИГЛАХ ТУХАЙ
БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР БА ЗСБНХУ-ЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Москва

1952 оны 9 дүгээр сарын 15

БНМАУ, СССР ба БНХАУ-ын хооронд төмөр замын шууд харилцаа байгуулах тухай Хэлэлцээрийн ёсоор ба уул хэлэлцээрт Улаанбаатараас Замын-Үүдийн орчим байгаа Монгол-Хятадын хил хүртэл төмөр замын шугам байгуулахаар заасныг биелүүлэх зорилгоор БНМАУ-ын Засгийн Газар ба Зөвлөлт Засагт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газрын Хэлэлцэн тохирсон нь:

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэгч Этгээдүүд нь Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн "Улаанбаатарын төмөр зам" нийгэмлэгийн ажиллагааг өргөтгөж, Наушки-Улаанбаатарын одоогийн байгаа төмөр замын үргэлжлэл болох дан замтай, 1524 миллиметр өргөн төмөр замыг Улаанбаатараас Замын-Үүдийн орчим байгаа Монгол-Хятадын хил хүртэл байгуулах ба ашиглахыг тус нийгэмлэгт даалгахаар хэлэлцэн тохиров. Уул төмөр замыг байгуулах явдлыг энэ хэлэлцээрт хавсаргасан бүдүүвч зурагт заасан чиглэлийг ёсоор гүйцэтгэнэ.

Дээр дурдсан төмөр замыг байгуулах ажлыг 1953 оны эцэст дуусгавал зохино.

Хоёрдугаар зүйл

1949 оны 6 сарын бнд байгуулсан Монгол-Зөвлөлтийн Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд тогтоосон Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн "Улаанбаатарын төмөр зам" нийгэмлэгийн хувь нийлүүлсэн хөрөнгийг Хоёр Талын хэлэлцээгээр жич тодорхойлогдох хэмжээгээр 1953 онд нэмэгдүүлэхээр Хэлэлцэгч Этгээдүүд тохиролцов.

Гуравдугаар зүйл

Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатарын төмөр зам” нийгэмлэгийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах нэмэгдэл төлбөрийг хоёр талаас дараахь журмаар нөхөн гаргах, үүнд

1. Зөвлөлтийн Тал нь нийгэмлэгийн хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрийн нэмэгдэл төлбөрийг рублиэр төлөх бөгөөд түүнийг төлөх өдрийн ханшаар төгрөг болгон бодож зохих мөнгийг Москва дахь банканд байгаа нийгэмлэгийн дансанд оруулах замаар гүйцэтгэнэ.

2. Монголын Тал нь нийгэмлэгийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд нэмэгдэл төлбөрийг төлөх журам нь:

А) “Улаанбаатарын төмөр зам” нийгэмлэгийн хувь нийлүүлсэн нэмэгдэл хөрөнгийг тодорхойлоход хоёр Талын хэлэлцээгээр тогтоогдож, БНМАУ-ын дотор Зам Барилгын Хэрэг Эрхлэх Газрын хэрэгцээнд адуу, гэр, барилгын материал, хүнс, хувцас болон бусад барааг худалдан авахад зориулагдах хэмжээний төгрөгийг Монголын худалдаа үйлдвэрийн банкад байгаа нийгэмлэгийн дансанд оруулна.

Б) Төмөр замын бүх шугамын дагуу 120 метр өргөн зурвас газар ба харин станцууд дээр уртаашаа 2000 метр хүртэл, өргөөшөө 300 метр газрыг нийгэмлэгт хугацаагүйгээр хэрэглүүлэхээр шилжүүлнэ. Энэхүү газрыг хугацаагүйгээр хэрэглүүлсний хөлсийг бодохдоо нийгэмлэгийн хувь нийлүүлсэн нэмэгдэл хөрөнгөний хэмжээг тодорхойлоход тогтоох ерөнхий хэмжээгээр үнэлбэл зохино.

В) Дээр дурдсан зурвас газруудаас гадна техникийн байшин барилга (үүний дотор цахилгаан станц, гидростанц) ба тэдгээрт туслах чанарын байруудыг босгох, түүнчлэн төмөр замыг барихад ба түүнийг цааш ашиглах явдалд хэрэглэгдэх хэмжээний барилгын материал (үүний дотор мод) бэлтгэхэд зориулагдах хэсэг газруудыг нийгэмлэгт хугацаагүйгээр хэрэглүүлэхээр шилжүүлнэ. Энэ зүйлд дурдсан хэсэг газруудын нийг талбай, мөн хэсэг газруудыг хугацаагүйгээр хэрэглэсний хөлсийг нэмэгдэл Хэлэлцээрээр тогтооно.

Г) Нэмэгдэл Хэлэлцээрээр тогтооход төгрөгийн хэмжээтэй тэнцэх рублийг ССРСР-ийн Улсын банканд байгаа нийгэмлэгийн дансанд оруулна. Төгрөг болгон бодохдоо төлөх өдрийн ханшаар гүйцэтгэнэ. Энэ зүйлд дурдсан төлбөр нь энэ хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасан зээллэгээр төлөгдөнө.

Дөрөвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн 3-аар зүйлийн "г"-д дурдсан Монголын Талын нэмэгдэл хувь төлбөрийг нийгэмлэгийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд төлөхөд зориулагдах төгрөгийн хэмжээтэй тэнцэх зээллэгийг ЗСБНХУ-ын Засгийн Газраас тусгай Хэлэлцээрийн журмаар БНМАУ-ын Засгийн Газарт рублиер олгоно.

Тавдугаар зүйл

Төмөр замын шинжилгээ барилгын ажлыг зөвлөлтийн Барилгын Хэрэг Эрхлэх Газраас тус Газар ба монгол-зөвлөлтийн хувь нийлүүлсэн "Улаанбаатарын төмөр зам" нийгэмлэгийн хооронд байгуулагдах тусгай Хэлэлцээрийн үндсэн дээр гүйцэтгэхийг Хэлэлцэгч Этгээдүүд зөвшөөрөлцөв.

Барилгын Хэрэг Эрхлэх Газар нь өөрийн салбар байгууллагуудын хамтаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутагт байрлана.

Зургадугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн "Улаанбаатарын төмөр зам" нийгэмлэгийг байгуулах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар ба Зөвлөлийн Засагт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газрын хооронд 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан Хэлэлцээрийн салшгүй хэсэг болох бөгөөд тэр Хэлэлцээрийн доторхи зүйлүүд нь тус хэлэлцээрээр үл өөрчлөгдөх тул Улаанбатараас Замын-Үүдийн орчим байгаа Монгол-Хятадын хил хүртэлх төмөр замыг тавих ба ашиглахад бүрэн хамаарагдана.

Долдугаар зүйл

Энэ Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд түүнийг тусгайлан батлах явдалгүй.

Энэ Хэлэлцээрийг Москва хотноо 1952 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр монгол, орос хэл дээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх нь хоёулаа адил хүчинтэй болно.

Бүгд Найрамдах
Монгол Ард Улсын
Засгийн газрын эрх
олгосноор Ю.Цэдэнбал

Зөвлөлийн Засагт
Социалист Бүгд
Найрамдах Холбоот
Улсын Засгийн газрын эрх
олгосноор А.Вышинский

*Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974.
Баримт материал. Хоёрдугаар боть.
1941-1974. Нэгдүгээр хэсэг.
УБ., 1981. т.226-229.*